



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/71

Бат-Өлзий сум

Золбин нохой устгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн золбин нохой устгалыг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 28-ны хооронд зохион байгуулсугай.

2. Золбин нохой устгалыг зохион байгуулах үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангаж, аюулгүй ажиллагааны заавар журмыг мөрдүүлэхийг Цагдаагийн тасгийн дарга (Д.Энх-Амгалан Цагдаагийн хошууч)-д, нохой устгах иргэнтэй гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга (Г.Бямбагарав), гэрээ байгуулсан иргэнтэй өдөр тутмын хяналтаар явж ажиллахыг Байгаль хамгаалагч (Ж.Батмөнх) нарт тус тус даалгасугай.

3. Нохой устгалын зардалд шаардагдах 3,300,000 (гурван сая гурван зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

